



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/481

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн 2022 оны Төсөв батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 5.22 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2022 оны Төсөв батлах тухай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 5.22 Нийтийн орон сууцанд дулааны улиралд хэрэглээний халуун усаар хангах ажилд 200 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх төсөл арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулагдах 200 000 000 төгрөг (хоёр зуун сая) -ийг санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын, хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2418  
Zah A/481 tum